

**БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗАР**



**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Тэшиг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн  
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн ХУРААНГУЙ тайлан

**Аудитын код: БУА-2025/005/НА-СТА-ТТЗ**

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Булган аймаг

2025 он

Дарга, Тэргүүлэх аудиторын албан тушаалын албан  
үүргийг түр орлон гүйцэтгэгч: Ж.Энхцоодол

Утас: 70342716 Цахим хаяг: [Enkhtsoodolj@audit.gov.mn](mailto:Enkhtsoodolj@audit.gov.mn)

Аудитор: Б.Энхтөр

Утас: 70342495 Цахим хаяг: [enkhturb@audit.gov.mn](mailto:enkhturb@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,  
63082, Утас/Факс:7034-2580  
Цахим шуудан:bulgan@audit.gov.mn

2025.03.24 № 358  
танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

БУЛГАН АЙМГИЙН ТЭШИГ  
СУМЫН ЗАСАГ ДАРГА  
Б.ГАНСҮХ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Тэшиг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тэшиг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тэшиг сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2024 оны төсвийн төсөлд нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,411.2 сая төгрөг, үйл ажиллагааны орлогоос 794.5 сая нийт зарлагыг 2,205.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн, орон нутгийн төсвөөс 700.0 сая төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөсөн байна.

Төсвийн төслийн саналыг 2205.7 сая төгрөгөөр өгсөн боловч тус саналаас зардлыг 1303.7 сая төгрөгөөр нэмж 3509.4 сая төгрөгөөр баталсан байна.

Энэ нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй төлөвлөсөн боловч орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт өссөн, засгийн газрын тогтоолоор цалин нэмэгдсэн, оны эхний үлдэгдлийг нэмж баталсан шалтгаалаан нэмэгдсэн байна.

**Аудитын гол асуудал**

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба

632502696

дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 790.3 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 762.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнаж 27.7 сая төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгийн хэмжээ өмнөх оноос 609.6 сая төгрөгөөр өсөж нийт хөрөнгө 904.8 сая төгрөгөөр өссөн нь "Тэшиг-Ус" ОНӨААТҮГ нь халаалтын тогоо, Засаг даргын Тамгын газар Орон нутгийн хөгжлийн сан, Байгаль хамгаалах сангийн хөрөнгө орлогод авсантай холбоотой өссөн байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Батлагдсан төсвийн хүрээнд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр 2024 онд 20 зорилтын 110 арга хэмжээ төлөвлөж жилийн эцэст төлөвлөгөөний биелэлтийг 96.4 хувьтай дүгнэгджээ.

АДБОУС 2706. 10-д зааснаар хууль тогтоомжоор хориглоогүй, аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй, тухайлбал аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүссэн тухай, санхүүгийн тайлангийн аудит, аудитын тайлантай холбоотой аудиторын хүлээх үүрэг хариуцлагын тухай дэлгэрэнгүй тайлбар өгөхөөр хууль тогтоомжоор шаардсан мэдээллийг тусгана.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН  
ТУШААЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

 Ж.ЭНХЦООДОЛ

## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
<b>Санхүүгийн байдлын тайлан</b>		
Эргэлтийн хөрөнгийн дүн	1,183,340,323.29	1,157,094,813.61
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,053,726,236.59	2,689,608,940.10
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>3,237,066,559.88</b>	<b>3,846,703,753.71</b>
Нийт өр төлбөрийн дүн	822,806,497.92	773,187,880.46
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,414,260,061.96	3,073,515,873.25
<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>3,237,066,559.88</b>	<b>3,846,703,753.71</b>
<b>Санхүүгийн үр дүнгийн тайлан</b>		
Үйл ажиллагааны орлогын дүн	5,670,699,942.38	6,874,692,679.62
Үйл ажиллагааны зардлын дүн	4,441,445,317.22	6,279,334,087.19
<b>Үйл ажиллагааны үр дүн</b>	<b>1,229,254,625.16</b>	<b>595,358,592.43</b>
Үйл ажиллагааны бус үр дүн		
<b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>	<b>1,229,225,782.04</b>	<b>595,358,592.43</b>
<b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b>		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	295,052,620.68	2,393,827,715.33
Тайлант оны үр дүн		595,358,592.43
<b>Эцсийн үлдэгдэл</b>		<b>3,073,515,873.25</b>
<b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	4,652,646,032.55	6,207,843,104.44
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	3,873,453,670.68	5,014,654,897.95
<b>Үйл ажиллагааны ЦМГ</b>	<b>779,192,361.87</b>	<b>1,193,188,206.49</b>
<b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>	<b>-493,546,572.00</b>	<b>-1,212,256,664.00</b>
<b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>	<b>-65,553,999.00</b>	<b>-8,677,188.00</b>
<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>220,091,790.87</b>	<b>-27,745,645.51</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	570,307,262.36	790,399,053.23
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	790,399,053.23	762,653,407.72
<b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан</b>		
<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>		<b>3,096,095,276.32</b>
Урсгал зардал		1,903,134,424.32
Хөрөнгийн зардал		1,184,283,664.00
<b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>		
Улсын төсвөөс санхүүжих		
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		100,984,379.00

### Гурав. Аудитын илрүүлэлт

#### Илрүүлэлт-1:

- Аудитаар нийт 4,029.6 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 4,029.6 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

#### 5.1 Төлбөрийн акт

#### 5.2 Албан шаардлага

#### 5.3 Зөвлөмж

1. Албан татварын орлого бүрдүүлэлттэй холбоотой.

*Илрүүлэлт: /Нөхцөл байдал, үр дагавар, нийцээгүй хууль тогтоомж, стандартын заалтыг бичих/*

Малын тоо толгойг 2023 оны эцэст нийт 97.4 мянган тоо толгой мал тоолуулж 60.1 сая төгрөгийн албан татвар ноогдуулахаас 44,000.0 мянган төгрөгийн татварыг төлөвлөж 4.1 сая төгрөгийн татвар дутуу төлөвлөсөн.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ" 41.2.1 дэх "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" заалтыг мөрлөж ажиллах.

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тэшиг сумын ТТЗ	1	4,029.6					1	4,029.6				
ЗДТГ	5	2,816.0			1	60.0	4	2,7056.0				
Ойн анги	2	135.9	1	120.0			1	15.9				
Тэшиг-Ус	4	129,425.1			2	6,204.0	2	123,107.6				
Тэшиг ИТХ	4	3,200.5	1	2,500.0			3	700.5				
ОНХС	2	0	2	3,290.1								
Тэшиг сум СТ	2	50.0	1	50.0			1	0				
Тэшиг ХХС	1						1	41,103.3				
<b>Дүн</b>	<b>21</b>	<b>184,050.7</b>	<b>7</b>	<b>5,960.1</b>	<b>3</b>	<b>6,264.0</b>	<b>13</b>	<b>171,826.6</b>				

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс
--------------------	-------------	--------



оны 07 дугаар сарын 01-ны өдрийн Б/03 тушаал гаргасан боловч жагсаалтаар өөртөө 50.0 мянган төгрөгийг авсан байна.												
Тамгын дарга дээр интернэтийн зардал давхар зардал гаргаж гэр интернэт цэнэглэсэн	1	60			1	60.0						
Уурын зуухны насосын ороолт, хөдөлгүүрийн ороолт тасарч гэмтсэн солих шаардлага үүссэн ч инженерийн техникийн тодорхойлолтгүйгээр 6.2 сая төгрөгийн ороолтыг Орхон аймгаас худалдан авч ороолгосон.	1	6204			1	6,204						
Малын тоо толгойг 2023 оны эцэст нийт 97.4 мянган тоо толгой мал тоолуулж 60.1 сая төгрөгийн албан татвар ноогдуулахаас 44,000.0 мянган төгрөгийн татварыг төлөвлөж 4.1 сая төгрөгийн татвар дутуу төлөвлөсөн.	1	4029.6				1	4,029.6					
Засаг даргын нөөц хөрөнгөөс Туулай жилийн аврагад хүндэтгэл үзүүлсэн боловч зориулалт бус зарцуулалт хийсэн	1	756				1	756.00					
ЗДТГ-ын хөрөнгөөр сонгуулийн самбар хийсэн	1	2000				1	2,000.0					
Тэшиг сумын ЗДТГ-ын хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг чанартай хийж гүйцэтгээгүй	1	0				1	-					
Тайлант онд татварын өглөг үүссэн.	1	15.9				1	15.9					
Үндсэн хөрөнгийг коджуулаагүй. /Үндсэн хөрөнгийн баар кодоор хэвлэж хөрөнгө бүр дээрээ наана./	1	123107.6				1	123,108					
Хангамжийн материалын 113.5 мянган төгрөгийн анхан шатны баримтын бүрдэлгүй.	1	113.5				1	113.5					
Хужирт багын соёлын төвийн засвар хийсэн тайлан мэдээгүй. (450.0, 250.5 мянган төгрөгөөр санхүүжилтийг олгосон)	1	700.5				1	700.50					
Тэшиг сумын ИТХ нь хөрөнгө, төлбөр	1	0				1	-					

тооцооны тооллогыг чанартай хийж гүйцэтгээгүй												
Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлттэй зээл авсан хуцаа хэтэрсэн 8 иргэний 41.1 сая төгрөгийн зээлийг барагдуулах	1	41103.3					1	41,103.3				
<b>Нийт дүн</b>	<b>17</b>	<b>184050.5</b>	<b>5</b>	<b>5960.1</b>	<b>2</b>	<b>6264</b>	<b>10</b>	<b>171826.4</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Шилэн дансны 170 мэдээлэл оруулахаас 11 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн	1	0			1	-		
Шилэн дансны 171 мэдээлэл оруулахаас 2 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн	1	0					1	-
Шилэн дансны 171 мэдээлэл оруулахаас 2 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн	1	0					1	-
Шилэн дансны 170 мэдээлэл оруулахаас 2 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн	1	0					1	-
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>0</b>			<b>1</b>		<b>3</b>	